



МОНГОЛ УЛСЫН  
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 05 сарын 05 өдөр

Дугаар A/107

Улаанбаатар хот

Цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагчийн түвшин тогтоох үзлэг явуулах батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагчийн түвшин тогтоох үзлэгийг 2021 оны 2, 3 дугаар улиралд зохион байгуулж явуулсугай.
2. “Цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагчийн түвшин тогтоох үзлэг явуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
3. Түвшин тогтоох үзлэгийг журмын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзориг, яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг нарт тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /хурандаа Б.Эрхэмбаяр/-т даалгасугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

1321100250

Батлан хамгаалахын сайдын 2021 оны  
05 дугаар сарын 05-ны өдрийн  
1107 дугаар тушаалын хавсралт

**ЦЭРГИЙН ЖИНХЭНЭ АЛБАНЫ ОФИЦЕР, АХЛАГЧИЙН  
ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГ ЯВУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь Цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагчийн түвшин тогтоох үзлэг /цаашид “үзлэг” гэх-/ийн зорилго, зарчим, хамрах хүрээ ба хугацаа, чиглэл, нэгтгэл, анги, байгууллага, хүн нэг бүрийн хүлээх үүрэг, үзлэгийн зохион байгуулалт, үр дүнг тооцохтой холбоотой харилцааг зохицуулна .

1.2. Үзлэг нь офицер, ахлагчийн мэргэшил, ур чадвар, албан тушаалын гүйцэтгэл, сахилга хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ, эрүүл мэндийн зэрэглэл, бие бялдар болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшинг тогтоо, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, цэргийн алба хаагчдын ёс зүйн төлөвшил албандаа хандах хандлага, нийгэмд эзлэх байр суурь, манлайллыг нэмэгдүүлэх зорилготой.

1.3. Цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагч 4 жил тутамд, дотоод, гадаадын цэргийн академи, их дээд сургууль төгсөгч болон офицер, ахлагч албан тушаалд шинээр томилогдсон цэргийн алба хаагч тухайн жилдээ түвшин тогтоох үзлэгт хамрагдана.

1.4. Үзлэг явуулахад баримтлах зарчим:

1.4.1.цэргийн удирдлагын байгууллага, нэгтгэл, анги, салбаруудын бэлэн байдал, өдөр тутмын үйл ажиллагааг алдагдуулахгүй байх;

1.4.2.үзлэгийг албан тушаал, цол, боловсролын түвшнээр нь ангилан явуулах;

1.4.3.шударга, үнэн зөв, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

1.4.4.үнэлгээний шалгуур, үнэлэх журам, хэрэгжүүлэх арга хэмжээ тодорхой байх;

1.4.5.хувь хүний болон мэргэжлийн нэр хүндийг хүндэтгэх, төрийн болон албаны нууц, хадгалалт, хамгаалалтын дүрэм, журам, зааврыг чанд мөрдөх.

1.5. Хамрах хүрээ:

1.5.1.цэргийн жинхэнэ албаны болон цэргийн гэрээт албаны офицер, ахлагч, офицер, ахлагчийн албан тушаалд туршилтын хугацаанд ажиллаж буй албан хаагчийг үзлэгт хамруулна.

1.5.2.энхийг дэмжих ажиллагааны өмнөх бэлтгэлд хамрагдаж байгаа бүрэлдэхүүн бэлтгэлийн хугацаанд, үүрэг гүйцэтгээд ирсэн офицер, ахлагч 3 сарын дотор үзлэгт хамрагдана.

1.5.3.дотоод, гадаадын цэргийн академи, их дээд сургуульд суралцагч, хүүхэд асрах чөлөөтэй болон жирэмсний амралттай, цэргийн албанаас халагдах, тэтгэвэрт гарах өргөдөл гаргасан, офицер, ахлагчийн орон тоонд ажиллаж байгаа цэргийн тэтгэвэрт гарсан бүрэлдэхүүн хамрагдахгүй.

Хоёр.Түвшин тогтоох үзлэг явуулах чиглэл, зохион байгуулалт

2.1.Түвшин тогтоох үзлэгийн дараах үндсэн чиглэлээр явуулна. Үүнд:

- Ажлын гүйцэтгэл, үр дүн, албаны хандлага, мэргэшлийн түвшин;
- Сахилга, ёс зүйн төлөвшил;
- Бие бялдрын бэлтгэлжилт;
- Эрүүл мэндийн байдал;
- Сэтгэл зүйн байдал.

2.2.Ажлын гүйцэтгэл, үр дүн, албаны хандлага, мэргэшлийн түвшин

2.2.1.Цэргийн алба хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, албаны хандлагыг ажлын гүйцэтгэл, ур чадвар, хандлага, зан үйлийн үнэлгээ болон багаар ажиллах чадвар зэрэг үзүүлэлтээр албан тушаалтан бүр дээр хамт олон үнэлгээний хуудсаар өгсөн үнэлгээ болон албан тушаалын шалгуур үзүүлэлтийг хангаж буй байдлыг нэгтгэл, анги, байгууллага, салбарын захирагч урьдчилан дүгнэж, баталгаажуулсан байна /хавсралт 1/.

2.2.1.1. Ажлын гүйцэтгэл, үр дүн, хандлагыг дараах үзүүлэлтийн нийлбэрийн дундаж оноогоор үнэлнэ. Үүнд:

-ЗХЖШ-ын даргын 2017 оны н/43 дугаар тушаалаар баталсан “Цэргийн алба хаагчийн албан тушаалын шалгуур үзүүлэлт”, алба хаагчийн албан тушаалын тодорхойлолтын шаардлагыг удирдлага болгон албан тушаалын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж байгаа байдал;

-өөрийн мэдлэг, чадвараа хөгжүүлж байгаа байдлыг алба хаагчийн танин мэдэхүй, техник, технологи, шинжлэх ухааныг судалж, соёл, урлаг, спортоор хичээллэдэг, өөрийгөө хөгжүүлдэг, гадаад хэл, албан тушаалын мэргэшүүлэх дамжаа, энхийг дэмжих ажиллагааны болон олон улсын хамтарсан сургалт, дадлагад хамрагдсан байдал, цэргийн хэргийн болон мэргэжлийн ур чадвараа нэмэгдүүлсэн байдал;

-ажлын цаг ашиглалт, идэвх чармайлт, үр дүнг цагийн бүртгэл, ажлын цаг ашиглалтын байдал, цагийн хуваарь, өдөр тутмын үйл ажиллагаа, ажил үүргээ гүйцэтгэхдээ гаргасан идэвх чармайлт, ажлын үр бүтээл;

-ахлах даргаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт, чанар байдлыг удирдлага, ахлах даргаас алба хаагчид тусгайлан өгсөн үүрийн хэрэгжилт, чанар;

-мэргэжлийн ур чадварыг офицер, даргалах албан тушаалын ахлагчийн баримт бичиг боловсруулалт, гүйцэтгэх тушаалын ахлагчийн практик дадлага чадвараар тус тус үнэлнэ;  
багаар ажиллах чадварыг цэргийн алба хаагчийн харьялал бүхий тухайн алба, тасаг, салбар, нэгжийн хамт олон үнэлнэ.

2.2.2. Мэдлэг, ур чадварын түвшин.

2.2.2.1.өрөнхий суурь мэдлэгийн түвшин /хууль эрх зүй, цэргийн нийтлэг дүрмүүд, цэргийн албыг зохион байгуулах заавар, офицер, ахлагчийн ёс зүйн дүрэм, оюуны чадавх, сэтгэн бодох чадвар/, цэргийн мэргэжлийн суурь мэдлэгийн түвшин /тактик, тусгай тактик, тусгай бэлтгэл, бусад мэргэшүүлэх хичээл/-г салаа, салбарын офицер, даргалах болон гүйцэтгэх албан тушаалын ахлагч гэсэн аngilllaar тус бүр 100 асуулт бүхий тестээр;

2.2.2.2.цэргийн гэрээт албаны офицер, ахлагчийг ерөнхий суурь мэдлэгийн түвшин, тухайн албан тушаалын мэргэжлийн ур чадвараар;

2.2.2.3.Зэвсэгт хүчний цэргийн мэргэжлийн болон цэргийн захиргааны удирдлагын байгууллага, бригад, хороо, батальоны штабын офицеруудыг байлдааны ажиллагааг төлөвлөн, зохион байгуулах, шийдвэр гаргах, цэрэгт үүрэг хүргэх, төрөл бүрийн тооцоо, өгөгдөхүүнийг бодох асуудлын хүрээнд тактикийн шуурхай дадлагын хэлбэрээр тус тус түвшинг тогтооно.

### 2.3. Сахилга, ёс зүйн төлөвшил

2.3.1.Сахилга хариуцлагын байдлыг тухайн нэгтгэл, анги, байгууллагын сайшаал, шийтгэлийн мэдээ, цагийн бүртгэл, гэмт хэрэг зөрчил, дүрмийн бус харьцааны судалгаа зэрэг мэдээллийг агуулсан алба хаагчийн ерөнхий мэдээллийн судалгаанд үнэлэлт өгөх. /хавсралт 2, 3/

2.3.2.Сүүлийн 12 сарын сахилга, дүрмийн бус харьцааны зөрчил, ажлын цаг ашиглалт, ажил эрхлэлт, цол олгогдсон байдал зэрэг үзүүлэлт бүхий асуумжид тусгагдсан асуудал тус бүрт тохирох оноог хасч, нийт оноог нэгтгэн үнэлнэ. /хавсралт 4/

2.3.3.Нийт 50 оно ба нэг асуумжийг дээрх загварын дагуу асуумж бүрт тохирох оноог хасч үнэлгээ өгнө. Хүснэгтэд заасан асуумжийн сахилгын зөрчлийн асуудал гаргаагүй бол хоосон үлдээж, хасах үзүүлэлтүүдийг нийт 50 оноонос хасч, үнэлнэ.

2.3.4. Хувь хүний ёс зүйн төлөвшил, цэргийн албаны хандлага, ёс зүйтэй ба ёс суртахууны эргэцүүлэлтэй байгаа эсэхийг тодорхойлох зорилготой өөрийн болон хамт олны үнэлгээг тусгайлан боловсруулсан асуумжаар тодорхойлох.

- тухайн цэргийн алба хаагч өөрийн үнэлгээг дүгнэж, асуумжийн хуудас дээр оноог тавина;

- хамт олны үнэлгээг тухайн нэгж, салбарт хамт ажиллаж байгаа цэргийн алба хаагчид асуумжийн дагуу дүгнэнэ.

### 2.4. Бие бялдрын бэлтгэлжилт

2.4.1. Бие бялдрын бэлтгэлжилтийг “Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн заавар”-ын дагуу хүч, авхаалж самбаа, уян хатны болон тусгай чанаараар насны ангиллаар бие бялдрын бэлтгэлжилтийн нормативыг гүйцэтгүүлж үнэлнэ.

2.4.2. Биеийн зохистой харьцааны үзлэгийг “Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт”-ын 12 дугаар зүйлд заасны дагуу явуулж, 2, 3 дугаар хавсралтын дагуу БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар болон яамны харьяа байгууллага, нэгтгэл, анги, байгууллага, салбарууд дотооддоо явуулсан байна.

### 2.5.Эрүүл мэндийн байдал

2.5.1. Бие бүрэлдэхүүний эрүүл мэндийн байдлыг сүүлийн 3 жилийн эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлт болон донтолт, стресс, зан төрхийн эмгэгийг илрүүлэх асуумж судалгааг үндэслэн дүгнэлт гаргана.

2.5.2. Эрүүл мэндийн дүгнэлтийн хуудсыг хүн нэг бүр дээр гаргах ба хуудасны дүгнэлт, авах арга хэмжээг комисс гаргана. /хавсралт 5/

### 2.6.Сэтгэл зүйн байдал

2.6.1. БХЯ, ЗХЖШ-аас Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбаруудад урьдчилан явуулсан “Зан байдал, хандлага, төлөвшлийн судалгаа”-ны дагуу “Мэдрэлийн цочирдолд орох ба сэтгэцийн эмгэг авах түвшинг тодорхойлох” тест, “Хувь хүний стресс үүсгэх хүчин зүйлд тогтвортой байх чадавхыг тодорхойлох” тест, “Хувь хүний зоригийн байдлын түвшинг тодорхойлох” судалгаануудыг үндэслэн дүгнэлт хийнэ.

2.6.2. Комисс нэгтгэл, анги, байгууллага, салбаруудын урьдчилан явуулсан судалгаанд дүгнэлт хийн ёс суртахуун, сэтгэл зүйн тогтвортой цэргийн алба хаагчдыг ангилж, сэтгэц-мэдрэлийн тогтвортой байдлын түвшинг “Прогноз-2” тестээр болон ганцаарчилсан уулзалт хийж мэргэжлийн дүгнэлт гаргана.

2.6.3. Сэтгэл зүйн бэлтгэлжилтийн дүгнэлтийн хуудсыг хүн нэг бүр дээр гаргах ба дүгнэлт, авах арга хэмжээг комисс гаргана. /хавсралт 6/

Гурав. Түвшин тогтоох үзлэг явуулах комисс, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, хүн нэг бүрийн хүлээх үүрэг

3.1. Үзлэг явуулах комисст /цаашид “комисс” гэх/ БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газраас тухайн чиглэлээр дадлага, туршлагатай ахлах мэргэжилтэн ба түүнээс дээших албан тушаалын бүрэлдэхүүнийг ЗХЖШ-ын даргын тушаалаар томилно.

3.1.1. Үзлэгийн комисс нь комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүдтэй байх ба үзлэгийг батлагдсан журмын дагуу, тогтоосон хугацаанд шударга, нээлттэйгээр зохион байгуулах, шалгалтын дүнг нэгтгэн батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагыг мэдээллээр хангах, цаашид офицер, ахлагчийн албыг хөгжүүлэх, чадваржуулахад чиглэгдсэн арга хэмжээг тодорхойлж танилцуулна.

3.1.2. Үзлэгийн комисс дараах үүрэгтэй байна. Үүнд:

- батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цэргийн мэргэжлийн удирдлагын байгууллага, нэгтгэл, анги, байгууллагын бие бүрэлдэхүүнийг мэргэжлийн арга зүйн удирдамжаар хангах;

- үзлэгт шаардлагатай шалгалтын хэрэглэгдэхүүнийг чиглэл хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдтэй хамтран үзлэг явуулах бэлтгэлийг хангаж, хуваарийн дагуу тасралтгүй, чанартай зохион байгуулах;

- үзлэгийн материалыг олшуулах, баталгаажуулах, битүүмжлэх ажлыг үзлэгийн комиссын нарийн бичгийн дарга хариуцах ба нууцлалыг чандлан хадгалах;

- түвшин тогтоох үзлэгийн дүнг нэгтгэж, үнэлж дүгнэх, акт бичих;

- үзлэгийн үнэлгээг нэгтгэн үзлэгт хамрагдсан бие бүрэлдэхүүнд танилцуулах;

- үзлэгийн үр дүнд шинжилгээ хийж, бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, офицер, ахлагчийн албаны манлайллыг хөгжүүлэх, нийгмийн хамгаалал, ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээг тодорхойлох, бодлогын баримт бичгийг шинэчлэхэд шаардлагатай мэдээлэл цуглуулах, санал боловсруулах.

3.2. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Зэвсэгт хүчний цэргийн мэргэжлийн болон цэргийн захиргааны удирдлагын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, нэгтгэл, анги, байгууллагын удирдлага, штабаас офицер, ахлагч нарыг үзлэгт бэлтгэх болон шалгалт явуулах нөхцөл боломжоор хангаж, бие бүрэлдэхүүнээ бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна.

3.2.1. Нэгтгэл, анги, байгууллага, салбарын удирдлага, штаб дараах үүрэгтэй байна. Үүнд:

- үзлэгт бэлтгэх төлөвлөгөө гарган баталгаажуулж, хэрэгжилтийг хангах;
- бие бүрэлдэхүүнтэй онолын болон дадлагын хичээл, сургалт явуулах, сургалтад шаардлагатай гарын авлага, материал хэрэгслээр хангах, зэвсэглэл, цэргийн техник дээр ажиллах, бие даан суралцах боломж нөхцөлийг бүрдүүлэх;
- хүн нэг бүрийн албан тушаалын тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг тодотгон, төрийн жинхэнэ албан хаагчийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг эхний хагас жилээр, цэргийн сургалт бэлтгэлийн шалгалтын дүнг нэгтгэн, бие бүрэлдэхүүнээ үнэлж дүгнэсэн байх;
- хүн нэг бүрийн сайшаал, шийтгэл, гэмт хэрэг, зөрчил болон дүрмийн бус харьцааны зөрчил, цагийн бүртгэл мэдээ, мэргэжил, сургалт, үйл ажиллагааны үнэлгээний дэвтрийг бүрдүүлж, хөтлөн, офицер, ахлагч нарын амьжиргааны түвшний судалгаа гарган, алба хаах картад баяжилт хийсэн байх;
- комиссын боловсруулсан асуумжийн дагуу цэргийн алба хаагчийн өөрийн үнэлгээ, хамт олны үнэлгээ авч, нэгтгэх, сахилга, хариуцлага, зан байдлын тодорхойлолт, алба хаасан ерөнхий мэдээллийг үнэн зөвөөр гаргаж, баталгаажуулах;
- үзлэгт хамрагдах бүрэлдэхүүнийг цэргийн төв эмнэлгийн эмч нарын комиссын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эмчийн дүгнэлт гаргуулах, цэргийн алба хаагч бүрийн сүүлийн 3 жилийн эрүүл мэндийн зэрэглэлийн судалгааг гаргаж, бэлтгэсэн байх;
- эрүүл мэндийн зэрэглэл буурсан бол шалтгааныг тогтоож, цэргийн төв эмнэлэг болон бусад төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн үзлэг, шинжилгээнд хамруулж, дүгнэлт гаргуулах, эмчлэх арга хэмжээг нэгтгэл, ангийн эмнэлгээс авч хэрэгжүүлэх; /тухайн жилд Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхээр сонгон шалгаруулалтад хамрагдаж, эрүүл мэндийн үзлэгээр орсон бол дүгнэлтийг тооцно/.
- донтолт, стресс, зан төрхийн эмгэгийг илрүүлэх асуумжийн судалгааг ангийн эрүүл мэндийн төвийн дарга, их эмч нар бие бүрэлдэхүүнээс урьдчилан авч, бэлтгэх;
- цэргийн алба хаагчдаас биеийн жингийн зохистой харьцааг тогтоож, түүний мөрөөр анги, байгууллагын удирдлагаас тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх, тайланг бэлтгэх;
- үзлэг явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх, шалгалтад бэлтгэж хэрэгжүүлсэн арга хэмжээ, санал, дүгнэлт бүхий тайланг бичиж, танилцуулга бэлтгэсэн байна.

3.3. Үзлэгт хамрагдах бүрэлдэхүүн энэ журамтай танилцан, үзлэгт бэлтгэж, хамрагдах, мэдлэг боловсрол, мэргэжил ур чадварын болон эрүүл мэнд, ёс зүй, бие бялдрын түвшнээ тогтоолгох үүрэгтэй.

3.3.1. Цэргийн алба хаагч нь дараах үүрэгтэй байна. Үүнд:

- цэргийн алба хаагч нэг бүр өөрийн талаарх мэдээллээ үнэн зөв мэдүүлж, бүх төрлийн судалгаанд бүрэн хамрагдах;
- хүн нэг бүр шаардлагатай хувийн бэлтгэлийг урьдчилан бэлтгэсэн байх;
- эмнэлгийн үзлэгт хамрагдаж эмчийн дүгнэлт гаргуулсан байх;
- биеийн жингийн зохистой харьцааг тавигдах стандартын хүрээнд хангах;
- хүн нэг бүрийн мэргэжил сургалт, үйл ажиллагааны үнэлгээний дэвтрийг зөв хөтөлсөн байх;

- цэргийн сургалт бэлтгэлийн стандартын дагуу хичээлүүдийг онолын түвшинд судлан, дадлага эзэмшсэн байх;
- шалгалтын явц, үр дүнгийн талаар комисст хандаж шаардлагатай мэдээлэл авах;
- хүндэтгэн үзэх шалтгаанаар шалгалтад хамрагдаагүй тохиолдолд тухайн шалтгаан арилсны дараа шалгалт явуулж байгаа ангид очиж, шалгалт өгөх.

Дөрөв. Офицер, ахлагчийг үнэлэх, үзлэгийн үр дүнг тооцох

4.1. Түвшин тогтоох үзлэгийн дүнг цэргийн алба хаагч тус бүрээр үзлэгийн чиглэл бүрт авсан оноо болон дүгнэлтийг үндэслэн гаргана. Үүнд:

д/д	Чиглэл	Агуулга	Авбал зохих оноо
1	Ажлын гүйцэтгэл, үр дүн, албаны хандлага мэргэшлийн түвшинг үнэлэх	ажлын гүйцэтгэл, үр дүн, цэргийн албаны хандлага	100 хүртэл
		мэдлэг, ур чадварын түвшин	100 хүртэл
2	Цэргийн алба хаагчийн сахилга, ёс зүйн төлөвшил	сахилга хариуцлагын байдал	100 хүртэл
		хувь хүний ёс зүйн төлөвшил	
3	Бие бялдрын бэлтгэлжилт	бие бялдрын бэлтгэлжилтийн норматив	100 хүртэл
		биийн жингийн зохистой харьцаа	тогтоох
4	Эрүүл мэндийн байдал	урьдчилан сэргийлэх үзлэг	дүгнэлт гаргах
		асуумж	
5	Сэтгэл зүйн дүгнэлт	урьдчилан явуулсан судалгааны дүн	дүгнэлт гаргах
		сэтгэл зүйн бататгах дүн	

4.1.1. Журмын 4.1-д тусгагдсан агуулга тус бүрээр дүгнэх асуулга, тест, дадлага бусад бэлтгэсэн шалгалтын материалын дагуу дүгнэж дараах дүгнэлтийг “Түвшин тогтоох үзлэгийн нэгдсэн дүнгийн хуудас”-д тэмдэглэнэ. /хавсралт 7/ Үүнд:

№	Агуулга	Үнэлгээ				
		90-100	80-89	70-79	60-69	59-өөс доош
1	Ажлын гүйцэтгэл, үр дүн, цэргийн албаны хандлага	манлайлагч	шаардлага хангасан	өөрийгөө дайчлах	бусдаас суралцах	хугацаатай үүрэг өгөх
2	Мэдлэг, ур чадварын түвшин	мэргэшсэн	мэргэшүүлэх сургалтад хамрагдах	өөрийгөө хөгжүүлэх	давтан сургалтад хамруулах	хүний нөөцөд бүртгэх
3	Сахилга хариуцлагын байдал		шаардлагыг хангаж байна	хамт олны дунд төлөвших	хариуцлагаа нэмэгдүүлэх	
4	Хувь хүний ёс зүйн төлөвшил	бусдад үлгэрлэгч			анхаарах шаардлагатай	мэргэжлийн сургалтад хамруулах

5	Бие бялдрын бэлтгэлжилтийн норматив	стандартыг бүрэн хангасан	хангалттай	өөрийгөө дайчлах	анхаарах шаардлагатай	6 сарын үүрэг өгөх
---	-------------------------------------	---------------------------	------------	------------------	-----------------------	--------------------

4.1.2.Ажлын гүйцэтгэл, үр дүн, цэргийн албаны хандлага мэдлэг, ур чадварын түвшин, сахилга хариуцлагын байдал түвшин, хувь хүний ёс зүйн төлөвшил, бие бялдрын бэлтгэлжилтийн нормативыг дүгнэх асуулга, тест, дадлага бусад бэлтгэсэн шалгалтын материалын дагуу тус бүрийг 100 оноогоор дүгнэж, арифметик дунджаар тухай цэргийн алба хаагчийн түвшинг дараах байдлаар ерөнхий дүгнэлт гаргана. Үүнд:

д/д	Оноо	Түвшин	Авах арга хэмжээ
1	90-100	маш сайн	Ажлын гүйцэтгэл, үр дүн нь албан тушаалын шалгуур үзүүлэлт, шаардлагыг маш сайн хангаж байгаа, цаашид дэвшиүүлэн томилох хүний нөөцөд бүртгэх
2	80-89	бүрэн хангалттай	Ажлын гүйцэтгэл, үр дүн нь албан тушаалын шалгуур үзүүлэлт, шаардлагыг бүрэн хангаж байгаа, цаашид албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах
3	70-79	хангалттай	Ажлын гүйцэтгэл, үр дүн нь албан тушаалын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж байгаа хэдий ч цаашид ажилдаа хандах хандлагаа сайжруулах шаардлагатай, албан тушаалд нь үргэлжлүүлэн болон шилжүүлэн ажиллуулах, өөрийгөө хөгжүүлэх тал дээр анхаарч ажиллах
4	60-69	сайжруулах шаардлагатай	Ажлын гүйцэтгэл, үр дүн нь албан тушаалын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахад дутагдалтай байгаа, өөрийгөө хөгжүүлэх талаар хугацаатай үүрэг өгөх, шаардлагатай гэж үзвэл албан тушаал бууруулан томилох
5	59-өөс доош	хангалтгүй	Ажлын гүйцэтгэл, үр дүн нь албан тушаалын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахгүй байгаа, цаашид цэргийн жинхэнэ албанаас халах саналыг тус тус оруулах

#### 4.1.3.Бие бялдрын бэлтгэлжилт

“Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт”-ын дагуу бие бялдрын бэлтгэлжилтийн норматив 64-өөс доош оноо авсан, биеийн жингийн зохистой харьцаа “хангаагүй” тогтоогдсон цэргийн алба хаагчдад 6 сарын хугацаатай үүрэг өгч, уг хугацаанд биелүүлээгүй тохиолдолд цаашид цэргийн жинхэнэ албанаас халах саналыг тус тус оруулах.

#### 4.1.4.Эрүүл мэндийн байдалд дараах дүгнэлтийг гаргана. Үүнд.

д/д	Агуулга	Дүгнэлт	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Эрүүл мэндийн зэрэглэл	Эрүүл, үүрэг гүйцэтгэх боломжтой	-Тогтоосон хугацаанд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж, дүгнэлт гаргуулж байх
2		Диспансерийн хяналтад байж эрүүлжүүлэх шаардлагатай	-Ангийн болон Цэргийн төв эмнэлгийн эмч нарын хяналтад байж, эрүүлжүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх
3		Цэргийн эмч нарын комиссоор оруулж,	-Цэргийн эмч нарын комиссын дүгнэлт гаргуулах;

		Цэргийн албанад эрүүл мэндээр тэнцэх эсэх талаар дүгнэлт гаргуулах	-Цэргийн албаны асуудлыг шийдвэрлүүлэх; -Ажлын нөхцөлийг өөрчлөх;
4		Эрүүл мэндийн байдалд дүгнэлт гаргах боломжгүй	-1 сарын хугацаанд урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамрагдсаны дараа эрүүл мэндийн хуудсыг комисст өгч, дахин дүгнэлт гаргуулах
5	Сэтгэцийн эрүүл мэндийн байдал	Стрессийн түвшин	-Шаардлагатай бүрэлдэхүүнд Цэргийн төв эмнэлгийн сэтгэцийн эмч, СЭМҮТ-ийн нарийвчилсан үзлэг, шинжилгээ хамруулж, оношийг тогтоож эрүүлжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ
6		Донтолтын дүгнэлт	
7		Зан төрхийн байдал	

4.1.5. Сэтгэл зүйн бэлтгэлжилтийн байдалд дараах дүгнэлтийг гаргана. Үүнд:

д/ д	Шалгуур үзүүлэлт	Тогтвортой	Хэвийн	Анхаарах шаардлагатай
1.	Сэтгэцийн эмгэг авах түвшин	+6-аас +61	+6-аас -1	-2-оос -69
2.	Хувь хүний стресс үүсгэх хүчин зүйлд тогтвортой байх чадвар	13-аас бага	13-аас 36	36-аас дээш
3.	Хувь хүний түгшүүр болон зоригийн байдлын түвшин	0-оос 4	5-аас 24	25-аас дээш

4.1.5.1. Сэтгэц—мэдрэлийн тогтвортой байдлын түвшинг “Прогноз-2” тестээр болон ганцаарчилсан уулзалтаар анхаарах шаардлагатай үнэлгээ авсан цэргийн алба хаагчдыг мэргэжлийн сэтгэл зүйчийн удирдлагын дор төлөвлөгөөт сэтгэл зүйн ажил явуулах дүгнэлт гаргана.

4.2. Үзлэгийн дүнг офицер, ахлагч нэг бүрийг “Түвшин тогтоох үзлэгийн нэгдсэн дүнгийн хуудас”-д бичиж, комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүд болон тухайн нэгтгэл, анги, байгууллагын захирагч, дарга нар, цэргийн алба хаагч гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулан нэг хувийг алба хаагчийн хувийн хэрэгт хавсаргана.

4.3. Бие бүрэлдэхүүнээс авсан асуумжийг үнэлж, шаардлагатай бүрэлдэхүүнд Цэргийн төв эмнэлгийн сэтгэцийн эмч, СЭМҮТ-ийн нарийвчилсан үзлэг, шинжилгээ хамруулж, оношийг тогтоож эрүүлжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ

4.4. Үзлэгтэй холбоотой гарсан санал, гомдлыг үзлэгийн комисст бичгээр гаргах ба комисс асуудлыг хянан шалгаж 3 хоногийн дотор хариу өгнө. Комиссын шийдвэрийг эс зөвшөөрвөл ЗХЖШ, харьяа төрлийн цэргийн командлал, удирдах газар, байгууллагын даргад үзлэг явагдсанаас хойш ажлын 5 хоногт багтаан гомдол гаргаж болно.

Тав. Бусад

5.1. Зэвсэгт хүчний Жанжин штаб түвшин тогтоох үзлэг явуулсан тухай тайланг үзлэг дууссанаас хойш нэг сарын дотор Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.2. Шалтгаангүйгээр үзлэгт хамрагдаагүй бүрэлдэхүүнийг хангалтгүй дүн үзүүлсэн буюу тухайн албан тушаалын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаагүйд тооцож хариуцлага хүлээлгэнэ.

5.3. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтан, хуулийн этгээдэд холбогдох хууль, цэргийн дүрмийн дагуу хариуцлага хүлээнэ.

--оОо--

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,  
ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН МЭДЭЭЛЭЛ	
Анги, байгууллагын нэр:	
Нэгжийн нэр:	
Албан тушаалтын нэр:	
Цол:	
Овог, нэр:	
Албан тушаалтын ангилал:	
Албан тушаалтын зэрэглэл:	
<b>АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ</b>	
1. Ажлын гүйцэтгэл, ур чадвар, хандлага, зан үйлийн үнэлгээ:	Оноо:
2. Багаар ажиллах чадварын хамт олны үнэлгээ:	Оноо:
Эцсийн үнэлгээ:	

Үнэлгээг өгсөн:

*Алба, масаг, салбар, нэгжийн дарга  
 Цэргийн цол ..... Гарын үсгийн тайлал  
 /гарын үсэг/*

Үнэлгээг баталгаажуулсан:

*Захирагч, дарга  
 Цэргийн цол ..... Гарын үсгийн тайлал  
 /гарын үсэг/  
 Огноо:*

## АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үзүүлэлт	Үнэлгээ	
		Авбал зохих оноо	Авсан оноо
Нэг. Ажлын гүйцэтгэл, ур чадвар, хандлага, зан үйлийн үнэлгээ /алба, тасаг, салбар, нэгжийн даргын үнэлгээ/			
1	Албан тушаалын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаж байгаа байдал	10	
2	Өөрийн мэдлэг, чадвараа хөгжүүлж байгаа байдал	10	
3	Ажлын цаг ашиглалт, идэвх чармайлт, үр дүн	15	
4	Ахлах даргаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт, чанар байдал	10	
5	Мэргэжлийн ур чадвар	15	
Хоёр. Багаар ажиллах чадвар /алба, тасаг, салбар, нэгжийн хамт олны үнэлгээ/			
6	Дүн шинжилгээ хийх	6.1. Тулгамдсан асуудлыг тодорхойлох чадвартай эсэх	5
		6.2. Аливаа асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай мэдээлэл цуглуулж, боловсруулж чаддаг эсэх /мэдээллийн хэрэгцээ болон эх сурвалжийг тодорхойлох/	5
7	Асуудал шийдвэрлэх	7.1. Удирдлага, ахлах даргын өгсөн үүрэг, чиглэлийн дагуу тодорхой арга хэмжээг зохион байгуулах	5
		7.2. Мэргэжлийн ур чадвар, мэдлэг, эрхэлсэн ажилдаа мэргэшсэн байдал	5
8	Багаар ажиллах	8.1. Хамт олон /алба, тасаг, салбар, нэгж/ дотроо илүү хариуцлага хүлээж ажилладаг байдал /хариуцлага хүлээх, аливаа сорилт тулгарахад бүтээлчээр хандаж, шийдвэрлэдэг байх/	5
		8.2. Шинэ мэдлэг өзэмшиж, түүнийгээ бусадтай хуваалидаг байдал /өөрийгөө байнга хөгжүүлэх, бусдын мэдлэг чадварыг хөгжүүлэхэд тусалж дэмждэг байх/	5
9	Бусад	9.1. Хувийн зохион байгуулалт /цагаа төлөвлөдөг, нэн яаралтай хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлдог, бэлтгэл ажлыг хангадаг гэх мэт/	5

		9.2. Алба хаагчийн шударга байдал, бусадтай тэгш харьцдаг эсэх	5	
		Нийлбэр оноо	100	
		Эцсийн үнэлгээ	.....	

Шалгалтын комиссын дүгнэлт:

.....  
 .....  
 .....  
 .....

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН САХИЛГА, ЁС ЗҮЙН ТӨЛӨВШЛИЙГ  
ТОДОРХОЙЛОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

<b>Цэргийн алба хаагчийн мэдээлэл</b>				
Эцэг / эхийн нэр:				
Өөрийн нэр:				
Цэргийн цол:				
Анги, байгууллагын нэр:				
Алба, салбарын нэр:				
Албан тушаалтын нэр:				
Д/д	Шалгуур үзүүлэлт	оноо		тайлбар
		авбал зохих	авсан	
<b>Сахилга хариуцлагын байдлын үнэлгээ /анги урьдчилан дүгнэх/</b>				
1.	Эрхэлсэн ажил, албан тушаалтын байдал	10		
2.	Цэргийн цол олгогдсон байдал	5		
3.	Цагийн буртгэл	10		
4.	Сайшаал	5		
5.	Шийтгэл	5		
6.	Гэмт хэрэгт холбогдож байсан эсэх	5		
7.	Дүрмийн бус харьцааны зөрчил гаргаж байсан эсэх	10		
<b>Ёс зүйн төлөвшлийн үнэлгээ /комиссын гишүүн дүгнэх/</b>				
8	Асуумж	50		
<b>Нийт оноо:</b>				

## Зан байдлын ерөнхий тодорхойлолт

Цэргийн алба хаагчийг үнэлсэн: албан тушаалт

Цэргийн цол ..... Гарын үсгийн тайлал  
/гарын үсэг/

## АЛБА ХААГЧИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

/байгууллага, албан тушаал/

/цол, овог, нэр/

1. Төрсөн.....он.....сар.....өдөр
2. Үндсэн захиргаа.....
3. Регистрийн дугаар..... хүйс.....
4. Цэргийн албанад элссэн он.....
5. Офицер, ахлагч болсон он, сар, өдөр.....
6. Боловсрол: .....
7. Мэргэжил: .....
8. Урьд болон одоо эрхэлж байгаа албан тушаал:

Д/д	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил, албан тушаал	Тайлбар
1.				Шилжүүлсэн, сэлгэсэн, дэвшүүлсэн, бууруулсан, албан үүргийг түр орлон гүйцэтгүүлсэн, албан тушаалаас түр чөлөөлсөн, халагдсан гэх мэт шалтгааныг харгалзах нүдэнд бичнэ.
2.				
3.				
4.				
5.				

## 9. Цэргийн цол /цол хуртсэн хугацааг огноогоор дараалан бичнэ/

Д/д	Цэргийн цол	Хугацаа	Тайлбар
1.			- албан тушаалын ангиллын дагуу олгогдсон, - ЦЖА хаасан хугацааны дагуу олгогдсон, - хугацаанаас өмнө олгогдсон гэх мэт шалтгааныг харгалзах нүдэнд бичнэ.
2.			
3.			

## 10. Сайшаал, шийтгэлийн мэдээ /сүүлийн 3 жил/:

Д/д	Мэдээлэл	Хэдэн удаа	Тайлбар
1	Сайшаал		- цэргийн дүрмийг чанд сахиж, цэргийн албаны үүргээ биелүүлэх талаар гаргасан амжилттыг үндэслэн, - цэргийн албаны үүргээ гарамгай биелүүлж, онцгой гавьяя байгуулсан, - тухайн сар, жилийн ажлын үзүүлэлтийг үндэслэн гэх мэтээр харгалзах нүдэнд бичнэ.
2	Шийтгэл		Цэргийн нийтлэг дүрмүүдийг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй гэх мэт шалтгааныг харгалзах нүдэнд бичнэ. Зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэн байдлыг тодорхой бичнэ.

11. Цагийн бүртгэл

Сүүлийн 12 сарын ажлын өдрөөр гаргана.

.....

12. Гэмт хэрэгт холбогдох байсан эсэх, дүрмийн бус харьцааны зөрчил гаргаж байсан эсэх

Д/д	Мэдээлэл	Тийм	Үгүй	Тайлбар
1	Гэмт хэрэгт холбогдох байсан эсэх	Тийм	Үгүй	Шүүхээр шийдвэрлэгдэж, хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх мэт.
2	Дүрмийн бус харьцааны зөрчил гаргаж байсан эсэх	Тийм	Үгүй	- ямар зөрчил, хэдэн удаа гаргасан. - сахилгын шийтгэлгүйд тооцогдсон эсэх

АНГИЙН ШТАБ

Хавсралт 4

САХИЛГА, ХАРИУЦЛАГЫН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

КОМИССЫН ГИШҮҮН  
Чэргийн

Մահմադեղ

/зарын үсэг/

Гарын үсгийн тайлал

卷之三

/CEM/H1406

ҮҮНЭЛГЭЭ ГАРГАСАН: албан тушаал

ЛЭДЭГНЭЛСҮҮН НОЛ

• • • • •

**Тайлбар:** Офицер, ахлагчийн сахилга, хариуцлагын байдлыг дээрх 18 асуумжийг дээрх загварын дагуу асуумж бурт тохирох оног хасч үнэлгээ өгнө. Хүснэгтэд заасан асуумжийн сахилгын зөрчлийн асуудал гаргаагүй бол хоосон үлдээж, хасах үзүүлэлтүүдийг нийт 50 онооноос хасч, үнэлгээ өгнө. Цэргийн алба хаагч бурийг үнэн зөв, бодит байдлаар үнэлж, үнэлгээг нэгтгэсэн байна.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДҮГНЭЛТИЙН ХУУДАС

.....  
/байгууллага, албан тушаал/.....  
/цол, овог, нэр/

Огноо.....

№	Шалгуур үзүүлэлт	Он	Зэрэглэл	Дүгнэлт
1.	Эрүүл мэндийн зэрэглэл /сүүлийн 3 жилээр/	20..... он	K-	
		20..... он	K-	
		20..... он	K-	
2.	Сэтгэцийн эрүүл мэндийн байдал	Стрессийн түвшин		
		Донтолтын дүгнэлт		
		Зан төрхийн байдал		

Дүгнэлт гаргасан: албан тушаал

Цэргийн цол .....

Гарын үсгийн тайлал

/гарын үсэг/

Огноо

## СЭТГЭЛ ЗҮЙН БЭЛТГЭЛЖИЛТИЙН ДҮГНЭЛТИЙН ХУУДАС

.....  
/байгууллага, албан тушаал/.....  
/цол, овог, нэр/

Огноо.....

№	Шалгуур үзүүлэлт	Тогтвортой	Хэвийн	Анхаарах шаардлага тай	Дүгнэлт
1.	Сэтгэцийн эмгэг авах түвшин	+6-аас +61	+6-аас -1	-2-оос -69	
2.	Хувь хүний стресс үүсгэх хүчин зүйлд тогтвортой байх чадвар	13-аас бага	13-аас 36	36-аас дээш	
3.	Хувь хүний түгшүүр болон зоригийн байдлын түвшин	0-оос 4	5-аас 24	25-аас дээш	

Дүгнэлт гаргасан: албан тушаал  
 Цэргийн цол ..... Гарын үсгийн тайлал  
 /гарын үсэг/

Огноо

## ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГИЙН НЭГДСЭН ДҮНГИЙН ХУУДАС

.....  
/байгууллага, албан тушаал/

.....  
/цол, овог, нэр/

1. Төрсөн.....он.....сар.....өдөр
  2. Үндсэн захиргаа.....
  3. Регистрийн дугаар..... хүйс.....
  4. Цэргийн албанд элссэн он.....
  5. Офицер, ахлагч болсон он, сар, өдөр.....
  6. Төгссөн сургууль, дамжаа /хаана, хэдэн онд, ямар мэргэжлээр/
- .....

7. Мэргэжилт.....  
а/ .....  
б/ .....  
в/ .....
8. Боловсролын эрдмийн зэрэг.....
9. Цэргийн мэргэжлийн зэрэг .....

10. Түвшин тогтоох үзлэгийн дүн:

Үнэлэх чиглэл	ОНОО		Дүгнэлт
	Авбал зохих	Авсан	
Ажлын гүйцэтгэл, үр дүн, албаны хандлага мэргэшлийн түвшин	ажлын гүйцэтгэл, үр дүн, цэргийн албаны хандлага	0-100	
	мэдлэг, ур чадварын түвшин	0-100	
Цэргийн алба хаагчийн сахилга, ёс зүйн төлөвшил	сахилга хариуцлагын байдал	0-50	
	хувь хүний ёс зүйн төлөвшил	0-50	
Бие бялдрын бэлтгэлжилт	бие бялдрын бэлтгэлжилтийн норматив	0-100	
	биеийн жингийн зохистой харьцаа	Хангасан, хангаагүй	
Нийт оноо		1-100	

11. Эрүүл мэндийн байдал

.....  
.....  
.....  
.....  
.....

12. Сэтгэл зүйн дүгнэлт

.....  
.....

13. Комиссын ерөнхий дүгнэлт

.....  
.....

Тэмдэг, байгууллагын дарга:

.....  
.....

/цол, овог, нэр, огноо/

Үзлэгийн комиссын дарга:

.....  
.....

/цол, овог, нэр, огноо/

Нарийн бичгийн дарга:

.....  
.....

/цол, овог, нэр, огноо/

Гишүүд:

.....  
.....

/цол, овог, нэр, огноо/

Үзлэгийн дүнг зөвшөөрсөн: /офицер, ахлагчийн гарын үсэг, огноо/

.....  
.....